



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 34

Мандалговь

**И.Замэндийг Татварын хэлтсийн Хуулийн
асуудал хариуцсан татварын улсын байцаагчийн
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Татварын хэлтсийн Хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Ичинхорол овогтой Замэндий 73.4 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа И.Замэндийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



**Татварын хэлтсийн Хуулийн асуудал хариуцсан
татварын улсын байцаагчийн албан тушаалд
нэр дэвшүүлсэн И.Замэндийгийн тухай дүгнэлт**

1. И.Замэндий нь 1995 онд Дундговь аймгийн Гурвансайхан суманд төрсөн. 27 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2013-2017 онд Их Засаг олон улсын их сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. И.Замэндийгийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Татварын хэлтсийн Хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

